

ХОЁР:ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

2.1 Алсын хараа

Чадварлаг боловсон хүчнээр хангагдсан, хариуцлага, хяналтыг үндсэн зарчим болгож төлөвшсөн, иргэддээ үзүүлэх соёлын үйлчилгээгээр тэргүүлсэн соёл урлагийн шилдэг байгууллага болохыг эрмэлзэнэ.

Эрхэм зорилго

Үндэсний өв уламжлалаа хадгалах, хамгаалах замаар соёлын үйлчилгээний эзлэх байр суурь, бүтээмжийг нэмэгдүүлэх, иргэдийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан чанартай үйлчилгээ үзүүлэх, улмаар орон нутгийнхаа соёлын хөгжлийг тэтгэх чадварлаг соёл урлагийн байгууллагыг төлөвшүүлэх эрхэм зорилготой.

Үнэт зүйлс

Мэргэшсэн, чадварлаг хүний нөөц. Мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвартай, өөрийгөө болон бусдыгаа байнга хөгжүүлдэг албан хаагчдаа бид үнэт зүйлс гэж үзнэ.

Манлайлал. Байгууллагын хөгжлийг олж тодорхойлогч, бусдыг үлгэрлэн дагуулж, урам зоригийг бадрааж, бодит үр дүнд хүрэх чадварыг бид үнэт зүйлс гэж үзнэ.

Мэргэжлийн бүтээлч хандлага. Асуудлыг бүтээлчээр шийдвэрлэх, сайжруулж хөгжүүлэх, шинэ санал, санаачлагыг бид үнэт зүйлс гэж үзнэ.

Үнэнч шударга зарчим. Хууль тогтоомжийг дээдлэн үнэнч шударга, өөриймсөг хандан сэтгэл гарган ажилладаг хандлагыг бид үнэт зүйлс гэж үзнэ.

Хамт олны нэгдмэл байдал. Хамт олны харилцан итгэлцлэл, хүндлэл, нэгдмэл байдлыг бид үнэт зүйлс гэж үзнэ.

Иргэд, олон нийтийн итгэл. Байгууллага, аж ахуйн нэгжийн хамтын ажиллагаа, олон нийтийн итгэл, хүндэтгэлийг бид үнэт зүйлс гэж үзнэ.

Байгууллагын туг, дүрэмт хувцас. Албан хаагчдын хийморь, золбоо, өргөсөн тангарагтаа үнэнч байх итгэл үнэмшил болсон албаны туг, дүрэмт хувцасаа бид үнэт зүйлс гэж үзнэ.

Уриа

Өв соёлоо дээдэлж-Шинэ ирээдүйг гэрэлтүүлнэ

Баримтлах зарчим

Соёлын төв нь үйл ажиллагаандаа дараах зүйлийг эрхэмлэнэ:

Мэдлэг чадвартай байх. Хариуцсан ажил үүргээ гүйцэтгэх мэдлэг, чадварыг эзэмшиж, түүнийгээ байнга хөгжүүлэн төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэнэ.

Мэргэшсэн тогтвортой байх. Хүний нөөцийн мэргэшсэн, тогтвортой байдлыг хангаж, албан хаагчийг ажлын байрны шаардлагад нийцүүлэн томилно.

Хариуцлага, ёс зүйтэй байх. Нийгмийн өмнө хүлээсэн төрийн албаны манлайлал, үүрэг, хариуцлагаа ухамсарлаж, төрийн албан хаагчийн ёс зүйг эрхэмлэж ажиллана.

Бүтээлч, санаачилгатай байх. Аливаа асуудалд шинжлэх ухаанч байдлаар хандаж, шинэ техник, технологи, инновацийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн албан хаагч бүр хариуцсан ажилдаа бүтээлч, санаачилгатай байна.

Шударга, ил тод, хуулийг дээдлэх. Хууль тогтоомжийг дээдлэн үйл ажиллагаандаа шударга ёс, ил тод, тэгш байдлыг хангана.

Суралцагч хамт олон байх. Суралцагч хамт олон байж, албан хаагчдын сурч хөгжих, ахиж дэвших орчныг бүрдүүлнэ.

Иргэд, олон нийтэд түшиглэх. Байгууллага, аж ахуйн нэгж, олон нийтийн түншлэл хамтын ажиллагааг өргөжүүлж, өөрийн үйл ажиллагаагаар тэдний итгэл, хүндэтгэлийг хүлээж, харилцан хамтарч ажиллана.

Хяналт-үр дүнг чухалчлах. Дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн ажлын гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг байнга үнэлж дүгнэж ажиллана.

2.2 Дунд хугацааны стратеги төлөвлөгөөгөөний хэрэгжүүлэх зарчмууд

- Төрийн үйлчилгээний чанарыг сайжруулж, бүтээмжийг нэмэгдүүлнэ
- Албан хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлж, хүний нөөцийн хөгжлийг хангана.
- Шинэ соёлын төвийг тохижуулах, үйлчилгээний орчныг бүрдүүлэх

2.3 Стратегийг хэрэгжүүлэх хугацаа

2024-2028 он

2.4 Стратегийн зорилт, үндсэн чиглэлүүд

Стратегийн зорилтууд	Үйл ажиллагааны зорилтууд
1.Соёл урлагийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх	1.1 Соёлын төвийн барилгыг шинээр барьж байгуулан ашиглалтанд оруулах
	1.2 Монголын уламжлалт ёс заншил эх хэл, түүх соёлоо дээдлэх, соёлын үйл ажиллагаагаар дамжуулан сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, баяжуулан хөгжүүлэх
	1.3 Ардын уламжлалт урлагийг сурталчлах, хөгжүүлэх
	1.4 Соёлын биет болон биет бус өвийг сурталчлах хамгаалах, өвлөн уламжлах, баяжуулан хөгжүүлэх
	1.5 Түүх соёлын дурсгалт газруудын бүртгэл мэдээллийн санг баяжуулах, олон нийтэд сурталчлан таниулах, хадгалж хамгаалах
	1.6 Сум орон нутгийн түүхийг судлан залуу хойч үедээ сурталчлан таниулах, өвлүүлэн баяжуулах
	1.7 Соёлын төвийн номын сангийн фонд баяжилтыг нэмэгдүүлэх
	1.8 Ном тойруулан соёл олон түмний ажлыг тогтмол зохион байгуулах
	1.9 Ардын авьяастан, чөлөөт уран бүтээлчдийн ур чадварыг нэмэгдүүлэх чиглэлээр дэмжин ажиллах
	1.10 Дугуйлан секцэд суралцагсдыг гадаад дотоодын уралдаан тэмцээнүүдэд амжилттай оролцуулах
	1.12 Урлагийн иж бүрэн хувцастай болох
	1.13 Соёл урлагаар үйлчлэх явуулын үйлчилгээний чанар хүртээмж, үр нөлөөг дээшлүүлнэ.
	1.14 Төрийн бус байгууллагуудтай хамтран соёлын олон талт арга хэмжээг зохион байгуулах
	1.15 Цахилгаан хөгжимтэй болох
	1.16 Хөгжим, техник хэрэгслийг нэмэгдүүлэх
2.Албан хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлж, хүний нөөцийн хөгжлийг хангана.	2.1 Албан хаагчдыг мэргэжил дээшлүүлэх курс, семинарт хамруулж мэдлэг, мэргэжлийг нь дээшлүүлэх арга хэмжээг шат дараатай хэрэгжүүлэх
	2.2.Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийн үнэлгээг оновчтой, тодорхойлох

	2.3 Соёлын салбарыг мэргэжлийн боловсон хүчнээр хангах, хөрвөх чадвартай ажилчдын тоог нэмэгдүүлэх
	2.4 Хөдөлмөрийн гэрээг ажил олгогчийг төлөөлөн байгуулах, гүйцэтгэлд нь хяналт тавих, дүгнэх
	2.5 Соёлын салбарт ажиллагсдыг мэргэшүүлэх
	2.6 Хамт олныг төлөвшүүлэх тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэх
	2.7 Соёлын төвийн ажиллагсдыг томилох, чөлөөлөх, урамшуулах, шийтгэх
	3.1 Орон нутаг судлах танхимыг тохижуулах
	3.2 Номын сангийн фонд, уншлагын танхимыг тохижуулах
3.Шинэ соёлын төвийг тохижуулах, үйлчилгээний орчныг бүрдүүлэх	3.3 Бүжгийн бэлтгэлийн өрөө болон дууны бэлтгэлийн өрөөг тохижуулах
	3.4 Үзвэрийн заал, тайзыг тохижуулах
	3.5 Үйлчилгээний заалнуудыг тохижуулах
	3.6 Байгууллагын гадна тохижилыг бүрдүүлэн ногоон байгууламжийг бий болгох

2.5 Үйл ажиллагааны хамрах хүрээ

Соёлын төвийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хамрах хүрээ нь

- ✓ Төрөөс баримтлах соёлын бодлого
- ✓ Соёлын тухай хууль
- ✓ Соёлын өвийг хамгаалах тухай хууль
- ✓ Номын сангийн тухай хууль
- ✓ Монгол хэлний тухай хууль
- ✓ Музейн тухай хууль, бусад хуулийн заалтуудыг удирдлага болгон

ажиллана.

Стратеги төлөвлөгөөг дараах нэгж хэсгүүдийн оролцоотойгоор хэрэгжүүлнэ.

Үүнд:

- ✓ Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
- ✓ Сумын Засаг даргын тамгын газар
- ✓ Ерөнхий боловсролын сургууль
- ✓ Сургуулийн өмнөх боловсролын байгууллагууд
- ✓ Багууд
- ✓ Төрийн бус байгууллагууд

2.6. Үйл ажиллагааны зорилтуудын шалгуур үзүүлэлт

Үйл ажиллагааны зорилтууд	Шалгуур үзүүлэлт	Санхүүгийн нөөц	Удирдлага, Зохион байгуулалт
1.Соёл урлагийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх			
1.1 Соёлын төвийн барилгыг шинээр барьж байгуулан ашиглалтанд оруулах	Соёлын үйлчилгээний орчин нөхцөл сайжирч, иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн үзвэр үйлчилгээг орон нутагтаа авчирах, ажилчдын ажиллах орчин нөхцөл бүрдэнэ	Улсын төсөв	ССАЖЗЯ Аймаг, сумын ИТХ ЗДТГ Соёлын төв
1.2 Монголын уламжлалт ёс заншил эх хэл, түүх соёлоо дээдлэх, соёлын үйл ажиллагаагаар дамжуулан сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, баяжуулан хөгжүүлэх	Залуу хойч үе эх хэл, түүх соёлоо танин мэднэ	Байгууллагын төсөв	Сумын ЗДТГ, ИТХ ЕБС СӨБ-ын байгууллагууд
1.3 Ардын уламжлалт урлагийг сурталчлах, хөгжүүлэх	Ардын авьяастнуудын ур чадвар дээшилнэ, ардын урлаг сурталчлагдана	Орон нутгийн төсөв Байгууллагын төсөв	ЗДТГ ААНБ-ууд Багууд Ардын авьяастнууд
1.4 Соёлын биет болон биет бус өвийг сурталчлах хамгаалах, өвлөн уламжлах, баяжуулан хөгжүүлэх	Соёлын өвийн бүртгэл мэдээллийн сан баяжигдана	Орон нутгийн төсөв Байгууллагын төсөв	ЗДТГ Багууд Соёлын өвлөн тээгчид
1.5 Түүх соёлын дурсгалт газруудын бүртгэл мэдээллийн санг баяжуулах, олон нийтэд сурталчлан таниулах, хадгалж хамгаалах	Сум орон нутгийн түүх соёл сурталчлагдана, залуу хойч үе бахархана	Орон нутгийн төсөв Байгууллагын төсөв	ЗДТГ Багууд ЕБС-ийн суралцагчид
1.6 Сум орон нутгийн түүхийг судлан залуу хойч үедээ сурталчлан таниулах, өвлүүлэн баяжуулах			

1.7 Соёлын төвийн номын сангийн фонд баяжилтыг нэмэгдүүлэх	Номын тоо нэмэгдэнэ, уншигчид, үйлчлүүлэгчид нэмэгдэнэ	Орон нутгийн төсөв Төсөл хөтөлбөрөөс	Аймгийн нийтийн номын сан ЗДТГ
1.8 Ном тойруулан соёл олон түмний ажлыг тогтмол зохион байгуулах	Номын сангийн үйл ажиллагаа сурталчлагдана	Байгууллагын төсөв	Иргэд ЕБС-ийн суралцагчид
1.9 Ардын авьяастан, чөлөөт уран бүтээлчдийн ур чадварыг нэмэгдүүлэх чиглэлээр дэмжин ажиллах	Ардын авьяастан, чөлөөт уран бүтээлчид, дугуйлангийн суралцагчдын ур чадвар дээшилнэ	Орон нутгийн төсөв Байгууллагын төсөв	Ардын авьяастан Чөлөөт уран бүтээлчид Дугуйлангийн суралцагчид
1.10 Дугуйлангийн суралцагчдыг гадаад дотоодын уралдаан тэмцээнүүдэд амжилттай оролцуулах			
1.12 Урлагийн иж бүрэн хувцастай болох	Тайзны тоглолтын чанар сайжирнэ	Орон нутгийн төсөв	ИТХ ЗДТГ
1.13 Соёл урлагаар үйлчлэх явуулын үйлчилгээний чанар хүртээмж, үр нөлөөг дээшлүүлнэ.	Хөдөөгийн алслагдсан малчин иргэд соёлын үйлчилгээнд хамрагдана	Орон нутгийн төсөв	Багууд
1.14 Төрийн бус байгууллагуудтай хамтран соёлын олон талт арга хэмжээг зохион байгуулах	Хамтын ажиллагаа бэхжинэ	Орон нутгийн төсөв Байгууллагын төсөв	Төрийн бус байгууллагууд Соёлын төв
1.15 Цахилгаан хөгжимтэй болох	Соёлын ажилчид, ардын авьяастнуудын авьяас, ур чадвар дээшилнэ. Дугуйлангийн суралцагчдын авьяасыг хөгжүүлнэ	БСШУСЯ-ны төсөв Орон нутгийн төсөв Төсөл хөтөлбөрөөр	ССАЖЗЯ ЗДТГ
1.17 Хөгжим, техник хэрэгслийг нэмэгдүүлэх	Байгууллагын материаллаг бааз нэмэгдэнэ	БСШУСЯ-ны төсөв	ССАЖЗЯ ЗДТГ

2.Албан хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлж, хүний нөөцийн хөгжлийг хангана.			
2.1 Албан хаагчдыг мэргэжил дээшлүүлэх курс, семинарт хамруулж мэдлэг, мэргэжлийг нь дээшлүүлэх арга хэмжээг шат дараатай хэрэгжүүлэх	Албан хаагчдын мэргэжил, мэдлэг дээшилнэ	Байгууллагын төсөв	БСШУСЯ СУИС Аймгийн БСУГ ажилчид
2.2.Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийн үнэлгээг оновчтой, тодорхойлох	Хөдөлмөрийн гэрээг ажилтантай байгуулан ажиллах бөгөөд уг төлөвлөгөө, гэрээний биелэлтийг үндэслэн тэдгээрийн үйл ажиллагаа, мэргэжлийн түвшинг тогтоосон хугацаанд нь үнэлж дүгнэнэ.	Байгууллагын төсөв	ЗДТГ Соёлын төв ажилчид
2.4 Албан хаагчдын нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлнэ	Ажилчдын нийгмийн баталгаа хангагдана	Байгууллагын төсөв	БСШУСЯ ЗДТГ Соёлын төв
2.5 Соёлын төвийн ажиллагсдыг томилох, чөлөөлөх, урамшуулах, шийтгэх	Хүний нөөц хангагдана Хууль тогтоомж хэрэгжинэ	Байгууллагын төсөв	ЗДТГ Соёлын төв
3.Шинэ соёлын төвийг тохижуулах, үйлчилгээний орчныг бүрдүүлэх			
3.1 Орон нутаг судлах танхимыг тохижуулах	Соёлын байгууллагын үйлчилгээний орчин нөхцөл сайжирна Байгууллагын материаллаг бааз нэмэгдэнэ Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн баталгаа дээшилнэ	БСШУСЯ-ны төсөв Орон нутгийн төсөв Төсөл хөтөлбөрөөр	БСШУСЯ Сумын ИТХ ЗДТГ Соёлын төв
3.2 Номын сангийн фонд, уншлагын танхимыг тохижуулах			
3.3 Бүжгийн бэлтгэлийн өрөө дууны бэлтгэлийн өрөөг тохижуулах			
3.4 Үзвэрийн заал, тайзыг тохижуулах			
3.5 Үйлчилгээний заалнуудыг тохижуулах			
3.6 Байгууллагын гадна тохижилыг бүрдүүлэн ногоон байгууламжийг бий болгох			

2.7 Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Соёлын төв нь дунд хугацааны стратеги төлөвлөгөөгөө Алсын хараа 2050, Төрөөс баримтлах соёлын бодлого, Соёлын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Номын сангийн тухай хууль, Монгол хэлний тухай хууль, аймаг, сум хөгжүүлэх төлөвлөгөө, 2024-2028 онд хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Сэлэнгэ аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрүүд, 2024-2028 онд хэрэгжүүлэх сумын Засаг дарга нарын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол улсын нэгдэн орсон Олон улсын гэрээ, конвенцууд /Соёлын биет бус өвийг хамгаалах тухай /2003/, Соёлын болон байгалийн өвийг хамгаалах тухай /1972/, Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжих тухай /2005/ зэрэг бодлогын баримт бичигтэй хэрхэн уялдаж байгааг дараах хүснэгтээр харуулав.

Стратегийн зорилтууд	Төрөөс баримтлах соёлын бодлогод тусгасан заалтууд	Соёлын тухай хуулийн заалтууд	Соёлын өвийг хамгаалах тухай хууль	Номын сангийн тухай хуульд зааснаар	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр	Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр
Соёл, урлагийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх	2.1.1.Үндэсний соёл, хөгжилд соёл, урлагийн эзлэх байр суурь, оруулах хувь нэмэр, үр ашгийг нэмэгдүүлэх; 2.1.3.соёлын өвийг хадгалж, хамгаалах, өвлөн уламжлах, баяжуулан хөгжүүлэх; 3.1.6.соёлын чиглэлээр төр, иргэний нийгэм, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг дэмжиж, соёлын үйл ажиллагаанд гэр бүл, иргэдийн тэгш оролцоог хангах;	17 дугаар зүйл. Соёлын байгууллагын нийтлэг үүрэг 1/ соёлын үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд мэргэжлийн ур чадвар, үйлчилгээний өндөр түвшинд явуулах;	14 ¹ .1.4.соёлын биет бус өвийг сурвалжлан олох, судалгаа шинжилгээ хийх, соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийг тогтоох, бүртгэх; 14 ¹ .1.8.устах, эвдрэх, гэмтэх аюул учирч байгаа соёлын өвийг авран хамгаалах, сэргээн засварлах арга хэмжээг боловсруулж, улс, орон нутгийн төсвийн болон хандивын хөрөнгөөр санхүүжүүлж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;	6.2.1.стандартад нийцсэн орчин нөхцөлд зохих үйлчилгээг уншигчид үзүүлэх; 6.2.2.уншигчид уншлагын үйлчилгээг зохих журмын дагуу хүргэх; 6.2.3.номын сангийн сан хөмрөгийн бүрэн бүтэн байдлыг хангах; 6.2.4.номын сангийн сан хөмрөгийн эргэлтэд байнга судалгаа хийж, бүрдүүлэлтийн чанарыг сайжруулах	1.Соёл, урлагийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, гадаад, дотоодод, үндэсний соёл, урлагийг сурталчлах, бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгоно. 2. Аймаг, сум, сургуулийн номын сангийн нөөцийг үндэсний болон дэлхийн сонгодог уран зохиолын номуудаар баяжуулж, үйлчилгээний	1.Соёл, спорт, урлаг уран сайхны нэгдсэн арга хэмжээ, олон улсын уралдаан тэмцээнд хүүхэд залуучууд, ахмад настнуудыг дэмжиж оролцоно 2. Соёлын биет ба биет бус өвийг хадгалан хамгаалах, нэгдмэл бодлогыг гаргаж, түүнийг хамгаалан цуглуулагч, тээн

	3.1.9.соёлын салбарт харилцан үр ашигтай гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх. 4.2.2.соёлын үнэт зүйлийг бүтээх, соёлын өвийг хадгалж хамгаалах, сурталчлах, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн иргэн, байгууллага, аж ахуйн нэгжийн санал санаачилга, үйл ажиллагааг дэмжих 4.2.4.орон нутгийн хүн амд урлагийн шилдэг бүтээл, соёлын иж бүрэн үйлчилгээ үзүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх;		14¹.1.9.соёлын өвийн бүртгэл мэдээллийн санг хөтлөх; 16.1.10.соёлын өвийг хамгаалахад идэвх, санаачилгатай оролцсон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах, хуульд заасан дэмжлэг үзүүлэх; 16.1.12.соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийг олж тогтоох, олон нийтэд таниулах, дэмжлэг үзүүлэх, өвлөн уламжлуулах ажлыг зохион байгуулах; 40.1.Соёлын өвийг сурвалжлан олсон, нээлт хийсэн, соёлын өвийн сан хөмрөгийг баяжуулах, авран хамгаалах, түүнийг олон нийтэд сурталчлан таниулах, сэргээн уламжлуулах, сэргээн засварлахад идэвх санаачилгатай ажилласан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг төрөөс урамшуулна.	арга хэмжээг тогтмол зохион байгуулах; 6.2.5.Монгол Улсын түүх, соёлын дурсгалт зүйлд хамаарах судар болон хуучин ном, гар бичмэлийг сурвалжлан олох, нөхөн бүрдүүлэх, олон нийтэд сурталчлах, хадгалах, хамгаалах хэвийн нөхцөлийг хангаж ажиллах 6.2.6.номын сан, ном зүйн мэдээллийг автоматжуулах, үйл ажиллагаандаа орчин үеийн техник, технологийг нэвтрүүлж, цахим мэдээллийн санг бий болгох; 6.2.7.номын сангийн үйл ажиллагааны тайлан, мэдээ, мэдээллийг хууль тогтоомжид заасан журмын дагуу холбогдох байгууллагад үнэн зөв гаргаж өгөх; 6.2.8.дотоод, гадаадын номын сан, эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран ажиллах.	хүртээмж, чанарыг дээшлүүлнэ. 3.Түүх соёлын дурсгалт зүйлсийг шинээр барих сэргээн засварлах ажлыг үе шаттай зохион байгуулна.	уламжлагч нарыг сурталчилна, дэмжиж ажиллана 3. “Танайд хүрч үйлчилнэ” соёл урлагийн явуулын үйлчилгээг алслагдсан малчид иргэдэд хүргэх, нүүдлийн номын сан, орон нутаг судлах танхимын үйл ажиллагааг сурталчлах, чанар хүртээмжийг сайжруулна. 4. Соёл урлагийн боловсролыг хүүхэд залуучуудад олгох, төрөл бүрийн дугуйлан сургалт зохион байгуулах 5. Соёлын ажилтнуудыг гадаад, дотоодын ижил төстэй байгууллагуудтай туршлага судлуулах, сум орон нутгаа сурталчлах, аймаг, улс, олон
--	---	--	--	---	--	--

						улсын чанартай уралдаанд чөлөөт уран бүтээлчид, ардын авьяастан, хүүхэд залуучуудын оролцоог нэмэгдүүлнэ 6. “Соёлын үйлдвэрлэл”, “Соёлын баримтат өвийг хамгаалах” хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна
2.Албан хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлж, хүний нөөцийн хөгжлийг хангана.	4.2.7.соёлын ажилтны нийгмийн баталгааны асуудлын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, үүнийг шийдвэрлэхэд нь бодитой туслалцаа дэмжлэг үзүүлэх, орон нутгийн соёл, урлагийн байгууллагыг мэргэжлийн ажилтнаар бүрэн хангаж, тэднийг тогтвор суурьшилтай ажиллуулах, нэмэгдэл цалин олгох, урамшуулал үзүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх;	соёлын ажилтны мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, нийгмийн баталгааг нь хангах. 22 дугаар зүйл. Соёлын ажилтны нийгмийн баталгаа 1/ тэтгэвэрт гарах үед ажиллаж байсан байгууллага нь тэтгэвэр тогтооход баримталсан хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын нэг жилийн дундажтай тэнцэх хэмжээний тэтгэлгийг тэтгэвэрт гарахад нь нэг удаа олгоно.			1.Соёл, урлагийн байгууллагуудыг мэргэжлийн боловсон хүчнээр хангах, чадавхижуулах, уран бүтээлчдийг урамшуулах бодлого хэрэгжүүлнэ.	1.Соёлын байгууллагын ажилчдын мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх, урт богино хугацааны сургалтанд хамруулах

	4.2.8.соёл, урлагийн ажилтны мэргэжил олгох, давтан болон мэргэшил дээшлүүлэх сургалтын шинэ тогтолцоо бүрдүүлж ажиллах;	2/ хөдөлмөрийн нөхцөл, мэргэжлийн онцлогийг харгалзан нэмэгдэл цалин, урамшил, эрдмийн зэрэг, цолны болон ур чадварын нэмэгдэл хөлс олгоно;				
3.Шинэ соёлын төвийг тохижуулах, үйлчилгээний орчныг бүрдүүлэх		1. Соёлын байгууллага нь улсын төсвийн болон орон нутгийн төсвийн хөрөнгө, бусад хөрөнгө оруулалт, дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хандив, хөнгөлөлттэй зээл, соёлын байгууллагын өөрийн орлого зэрэг санхүүгийн эх үүсвэртэй байна. 1/ соёлын салбарт тусламж дэмжлэг үзүүлэх зорилгоор хөрөнгө оруулалт хийх, хандив өргөх;			1.Сумын Соёлын төвийг шинээр барих ажлыг эхлүүлэх	1.Соёлын төвийн гадна талбайн гэрэлтүүлэг болон тохижилтыг сайжруулна

Стратегийн зорилтууд	Монгол хэлний тухай хуулийн заалтууд	Соёлын биет бус өвийг хамгаалах конвенцид тусгасан заалтууд	Соёлын болон байгалийн өвийг хамгаалах тухай конвенцид тусгасан заалтууд	Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжих конвенцид тусгасан заалтууд
Соёл, урлагийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх	6.1.1.төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, хуулийн этгээдийн үйл ажиллагаа, албан хэрэг хөтлөлт; 8.1.Монгол Улсын хэмжээнд кирил болон үндэсний бичгийн зөв бичих тус тусын нэгдмэл дүрэмтэй байх бөгөөд иргэн, хуулийн этгээд уг дүрмийг дагаж мөрдөнө. 17.1.3.үндэсний бичгийн хэрэглээг түгээн дэлгэрүүлэхэд идэвх санаачилга гарган ажиллаж байгаа иргэн, хуулийн этгээдийг урамшуулах ажлыг зохион байгуулах; 20.1.1.монгол хэл, бичиг үсгээ сурч судлах, өвлөх, өвлүүлэх, монгол хэлээ эзэмших, хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэх талаар санаачилга гаргах;	11 дүгээр зүйл а/ Өөрийн нутаг дэвсгэр дээрх соёлын биет бус өвийг хамгаалахад чиглэсэн шаардлагатай арга хэмжээ авна б/ Бүлэглэл, бүлэг болон төрийн бус холбогдох байгууллагуудын оролцоотойгоор өөрийн нутаг дэвсгэр дээрх соёлын биет бус өвийн төрөл зүйлийг таньж тогтоон тодорхойлно 14 дүгээр зүйл Боловсрол, олон нийтийн ойлголтыг дээшлүүлэх болон чадавхийг бэхжүүлэх 15 дугаар зүйл Соёлын биет бус өвийг бүтээх, хамгаалах, өвлүүлэх үйлсэд хамт олон, бүлэг хүмүүс, зарим тохиолдолд хувь хүмүүсийг аль болох өргөнөөр оролцуулж, уг өвийн хамгаалалтыг удирдахад тэднийг идэвхтэйгээр татан оролцуулна	6 дугаар зүйл 1.Нутаг дэвсгэртээ бие даасан соёлын өв бүхий улс орны бие даасан эрхийг бүрэн хүндэтгэж уг өвтэй харьцах үндэсний хууль зүйн эрхэд харшлахгүйгээр эдгээр бүх нийтийн өвийг болон улсын байгууллагатай хамтран хамгаалах үүрэгтэйг энэхүү конвенцид нэгдсэн орнууд хүлээн зөвшөөр чбайна 2.Байгалийн болон соёлын өв бүхий орнууд уг өвийг илрүүлэх, хамгаалах, хадгалах, сурталчлах талаар тусламж үзүүлэхийг хэрэв хүсвэл конвенцид нэгдэн орсон орнууд энэхүү конвенцийн дагуу дэмжлэг үзүүлэх үүрэг хүлээнэ.	1 дүгээр зүйл а/Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжих е/Соёлын илэрхийллийн олон төрлийг дээдлэн хүндэтгэж, түүний үнэ цэнийг ухамсарлан ойлгох явдлыг орон нутаг, үндэсний болон олон улсын түвшинд дээшлүүлэхийг хөхиүлэн дэмжих 7 дугаар зүйл 2.Талууд уран бүтээлчид, бүтээн туурвих үйл ажиллагаанд оролцдог бусад хүмүүс, соёлы салбарын хамт олон, тэдний үйл ажиллагааг дэмждэг байгууллагуудын оруулж буй чухал хувь нэмэр болон соёлын илэрхийллийн олон төрлийг тэтгэн баяжуулах тэдгээрийн үндсэн үүргийг мөн хүлээн зөвшөөрөх 10 дугаар зүйл а/Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах, хөхиүлэн дэмжихийн ач холбогдлыг боловсролын болон олон нийтийн дундах ойлголтыг нэмэгдүүлэх хөтөлбөрүүдээр дамжуулан дэмжин хөхиүлнэ 12 дугаар зүйл с/Соёлын илэрхийллийн олон төрлийг хөхиүлэн дэмжих

				зорилгоор иргэний нийгэм, төрийн бус байгууллагууд, хувийн хэвшил болон тэдгээрийн хооронд түншлэлийг бэхжүүлнэ.
2.Албан хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлж, хүний нөөцийн хөгжлийг хангана.	19.1.1.монгол хэлний зөв бичих дүрэм, орчин цагийн утга зохиолын монгол хэлний хэм хэмжээг чанд баримтлах;			
3.Шинэ соёлын төвийг тохижуулах, үйлчилгээний орчныг бүрдүүлэх	17.1.2.харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд албан байгууллага, гудамж, талбайн нэр хаягийг кирилл болон үндэсний бичгээр хослуулан, эсхүл дангаар нь бичиж хэвших ажлыг зохион байгуулах;			

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:
ЕРӨӨ СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН
ДАРГА Ф.БОЛОРМАА

